



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 82

Мандалговь

Г

Г

Үнэлгээ тогтоож, худалдах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоол, “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлага худалдаа зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ Нь:

Нэг: Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1983 онд ашиглалтанд орсон 35,814,533.76 / Гучин таван сая найман зуун арван дөрвөн мянга таван зуун гучин зургаан төгрөг далан зургаан/ мөнгөний өртөгтэй, 16,265,867.4 /Арван зургаан сая хоёр зуун жаран таван мянга найман зуун жаран долоон төгрөг дөрвөн/ мөнгөний үлдэгдэл өртөгтэй Цэцэрлэгийн хуучин барилгыг газаргүйгээр худалдах доод үнийг 6,000,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр, Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2010 онд ашиглалтанд орсон 2,651,500 / Хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга таван зуун/ төгрөгийн өртөгтэй, 2,069,642.95 /Хоёр сая жаран есөн мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг ерэн таван/ мөнгөний үлдэгдэл өртөгтэй Сауны барилгыг доорхи газрын хамт худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая / төгрөгөөр тогтоон тус тус худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч /А.Алтанчимэг/, Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын дарга /Ц.Дуламсүрэн/ нарт тус тус даалгасугай.

Дөрөв: Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн 70 дугаар тогтоол, 2018 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 07 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

Тав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СУХБААТАР

0100194